

ТАНИЛЦУУЛГА

“Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

Манай улс БНХАУ-тай “БНМАУ, БНХАУ-ын хооронд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ”, “Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай Монгол Улс, БНХАУ-ын хоорондын гэрээ”, “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс болон БНХАУ-ын хоорондын гэрээ” байгуулсан байдаг. Гэхдээ эдгээр гэрээ нь засаг захиргааны онцгой бүс болох Хонконг болон Макао д үйлчилдэггүй. Тиймээс Монгол иргэдийн зорчих хөдөлгөөн нэмэгдэж, гэмт хэрэгт ихээр холбогдох болсон Хонконг, Макао зэрэг засаг захиргааны онцгой бүсүүдтэй тусгайлсан хэлэлцээрүүдийг байгуулахаар ажиллаж байна.

Монголчууд ихээр зорчин аливаа төрлийн гэмт хэрэгт холбогдох болсон зарим улс орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ байгуулах бодлогын хүрээнд Хууль зүйн сайдын 2012 онд БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгд айлчлал хийх үеэр Хонконгийн талд “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай” болон “Ялтан шилжүүлэх тухай” хэлэлцээрүүд байгуулахыг санал болгож “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2016 онд байгуулсан.

“Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг талууд эцэслэн тохиролцож, УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэн дэмжсэн болно. Улмаар Хонконгийн талаас 2017 оны 6 дугаар сард хэлэлцээр байгуулахад бэлэн байгаагаа мэдэгдэж, талууд 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгд гарын үсэг зурсан.

2018 оны 8 дугаар сарын байдлаар Монгол Улсын 35 иргэн Хонконгд ял эдэлж байна.

Тус хэлэлцээр нь 23 зүйлтэй, эрх зүйн туслалцааны хүсэлтүүдийг зүйл бүрээр зохицуулсан байх бөгөөд зардал, эрх зүйн туслалцааны хүсэлтийн агуулга, харилцах төв байгууллагууд, хүсэлтийг биелүүлэхээс татгалзах үндэслэлүүдийг заасан болно.

Энэхүү хэлэлцээрийг байгуулснаар хоёр улсын хууль сахиулах байгууллагууд эрүүгийн хэргийн мөрдөн байцаах, шүүн таслах, яллах ажиллагаанд хурдан шуурхай хамтран ажиллах эрх зүйн орчин бүрдэх юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР